



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/308

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны журмыг 1 дүгээр хавсралтаар, Холбоо, навигаци, ажиглалтын албаны журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (П.Пүрэвсүх), Холбоо, навигаци, ажиглалтын алба (М.Эрдэнэсүх)-нд, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн үйлчилгээний газар (Э.Төрбаяр), Захиргаа, хүний нөөцийн газар (Р.Амарбаясгалан), Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг), Дотоод хяналтын алба (И.Амарсанаа)-нд тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны А/209 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн  
4/3.08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (цаашид "НХҮА" гэх) нь ИНД-172 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт" дүрмээр гэрчилгээжиж, иргэний нисэхэд ашиглах Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүдэд аюулгүй, үр ашигтай нислэгийн хөдөлгөөний удирдлага, нислэгийн мэдээллийн үйлчилгээ, анхааруулах үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид "ИНЕГ" гэх)-ын харьяа Иргэний нисэхийн үндэсний төв (ИНҮТ)-ийн салбар нэгж юм.

1.2. НХҮА нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, хөтөлбөр, олон улсын стандарт, ИНЕГ, ИНҮТ-өөс батлан гаргасан тушаал, шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, холбогдох бусад эрх зүйн баримт бичиг болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Журмын зорилго нь НХҮА-ны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, бүтэц, удирдлага зохион байгуулалт, эрх, үүрэг, төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

### Хоёр. Албаны нэр, оршин байгаа хаяг

2.1. Албаны оноосон бүтэн нэр "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба", товчилсон нэр нь "НХҮА" байна.

2.2. НХҮА-ны оршин байгаа газар нь: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа

2.3. Шуудангийн хаяг: 17120 Улаанбаатар хот, Буянт-Ухаа, Утас: 976-71281700, Факс: 70049525

### Гурав. НХҮА-ны бэлгэдэл, тамга тэмдэг

3.1. НХҮА нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн хяналтын дугаар бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3.2. НХҮА нь үйл ажиллагааны онцлог шинж чанарыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна. Бэлгэдлийн загварыг ИНҮТ-ийн дарга батална.

### Дөрөв. Үйл ажиллагааны чиг үүрэг

4.1. НХҮА нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1 Бүсийн удирдлагын үйлчилгээ;

4.1.2 Ойртолтын удирдлагын үйлчилгээ;

4.1.3 Аэродромын удирдлагын үйлчилгээ;

4.1.4 Нислэгийн мэдээллийн үйлчилгээ;

4.1.5 Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;

4.1.6 Анхааруулах үйлчилгээ;